

*“Хутагт Насан хийгээд
Цаглашгүй Билгэ Билгүүний Судар”*



Зургийг авсан хаяг: <http://www.fodian.net/world/amt/amtayus/amtayus0.jpg>

“Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар”

[Насны Цэнд Судар] хэмээх их хөлгөний судар оршвой

Энэтхэгийн хэлнээ: Аря Апарамита Аюраена Нама Махаяна Сутра

Түвдийн хэлнээ: ༄། །འཕགས་པ་ཚེ་དང་ཡི་ཤེས་དབག་དུ་མིན་པ་ཐེག་པ་ཆེན་པོའི་མཛོ་བཞུགས་སོ།།

Англи хэлнээ: Great Vehicle Sutra of Unfathomable Exalted Life and Transcendental Wisdom

Монгол хэлнээ. “Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар” хэмээх их хөлгөний судар

Хамаг бурхад, бодьсадва нарт мөргөмүй!

Ийн хэмээн миний сонссон тэр нэгэн цагт Ялж Төгс Нөгцсөн[1] Түүнчлэн Ирсэн[2], Дайснаа Дарсан[3], Үнэн Төгс Туулсан[4] Бурхан багш Шравасти хотын[5] Жэтавана[6] цэцэрлэгт, хотлыг баясгагчийн өглөгийн эзний[7] хүрээнд мянга хоёр зуун тавин аяга тахимлигийн[8] ихэс хуврагууд хийгээд асар олон бодьсадва[9], махасадва[10] нар лугаа хамт залран байлаа.

Ялж төгс нөгцсөн бурхан багш орь залуу Манзушрид хандан “Манзушри, Эрдэм цаглашгүй хэмээгдэх нэгэн орон буй. Энэ эрдэм цаглашгүй хэмээх орноо дайснаа дарсан, төгс гэгээрсэн, машид тийн илтэд сүр жавхлангийн хаан хэмээгдэх Аюуш бурхан заларч амьтан бүхэнд дээдийн номыг номлон буй бөлгөө.”

Орь залуу Манзушри, Энэ цагт замбуу тивийн хүмүүн төрөлхтөн зуу наслах хэдий ч ихэнх нь цаг бусаар нас нөхцөх болой.

Манзушри, түүнчлэн ирэгсдийн Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний [Насны Цэнд] судар үүнийг орон гэртээ хадгалсан, уншсан, энэ судрын нэрийг тогтоосон, сонссон, бичсэн хийгээд бусдаар бичүүлсэн хэн бээр ч, бас насны хэмжил дуусч буй хэн бээр ч цэцэг хийгээд цэцгэн эрхи, үнэртэн, хүж, чимэг зүүлт өргөн тахиж, хүндэлсэн тэр бүгдийн насны хэмжээ дахин нэг зуугаар уртасмуй.

Манзушри, Түүнчлэн Ирсэн, Дайснаа Дарсан, Төгс Гэгээрсэн, Машид Тийн Илтэд Сүр Жавхлантын алдрыг зуун найман тоот сонссон тэр бүгдийн насны хэмжээ уртсах болой. Мөн хэн бээр насан хэмжээ дуусах дөхсөн ч эдгээр түүнчлэн ирэгсдийн нэрийг санах төдий тэр бүгдийн насан хэмжээ уртсах болой. Манзушри, иймийн тул урт наслахыг хүсэгч сайн буянт хүү, охин хэн бүгд Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судрын нэрийг зуун найман тоот сонссон, бичсэн, бусдаар бичүүлсэн хийгээд давтсан түүний буян машид арвидах болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА

Манзушри, Хэн бээр түүнчлэн ирэгсдийн нэр алдрыг зуун найман тоот уншсан, орон гэртээ хадгалсан, сударт буулгасан, бичсэн хийгээд бусдаар бичүүлсэн тэдгээрийн насны хэмжээ нэгэн зуугаар уртасмуй. Үхэл ирэхийн цагт, мөн үхэл ирсэн хойно дахин төрөл авахын цагт ч Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний түүнчлэн ирэгсдийн ариун орноо төрөх болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Манзушри, Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг ерөн есөн дүнчүүр [990 000 000] бурхан бүгд нэгэн аялгуу, нэгэн зоригдлоор номлосон болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Манзушри, Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг наян дөрвөн дүнчүүр [840 000 000] бурхан бүгд нэгэн аялгуу, нэгэн зоригдлоор номлосон болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Манзушри, Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг далан долоон дүнчүүр [770 000 000] бурхан бүгд нэгэн аялгуу, нэгэн зоригдлоор номлосон болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Манзушри, Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг жаран таван дүнчүүр [650 000 000] бурхан бүгд нэгэн аялгуу, нэгэн зоригдлоор номлосон болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Манзушри, Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг тавин таван дүнчүүр [550 000 000] бурхан бүгд нэгэн аялгуу нэгэн зоригдлоор номлосон болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Манзушри, Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг дөчин таван дүнчүүр [450 000 000] бурхан бүгд нэгэн аялгуу нэгэн зоригдлоор номлосон болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Манзушри, Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг гучин зургаан дүнчүүр [360 000 000] бурхан бүгд нэгэн аялгуу нэгэн зоригдлоор номлосон болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Манзушри, Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг хорин таван дүнчүүр [250 000 000] бурхан бүгд нэгэн аялгуу нэгэн зоригдлоор номлосон болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Манзушри, Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг арван их далайн элсний тоотой тэнцүү арван сая бурхан бүгд нэгэн аялгуу нэгэн зоригдлоор номлосон болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг бичсэн, бусдаар бичүүлсэн тэдгээрийн насан хэмжээ нэгэн зуугаар уртасмуй.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг бичсэн, бусдаар бичүүлсэн тэдгээр бүгд адгуус, там, бирдийн гурван муу заяанд үл төрөх бөгөөд мөн тэд чөлөө учралгүй [дээдийн ном дэлгэрээгүй] газар оронд үл төрөх билээ. Аль ч газар төрсөн тэд бүгдээр өмнөх төрлүүдээ илэрхий санах болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг бичсэн, бусдаар бичүүлсэн тэдгээр бүгд Бурхан багшийн наян дөрвөн мянган сургаалыг [84 000] бичсэн тэр бүхэнтэй адил болой. [Бурхан багшийн бүх сургаалыг бичиж дээдэлсэнтэй адил тус эрдэмтэй]

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг бичсэн, бусдаар бичүүлсэн тэдгээр бүгд Бурхан багшийн наян дөрвөн мянган сургаалыг [84 000] бичүүлсэн хийгээд залсантай адил болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг бичсэн, бусдаар бичүүлсэн тэдгээрийн завсаргүй таван муу үйл, нүгэл бүгд ариусмуй.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг бичсэн, бусдаар бичүүлсэн тэдгээрийн муу үйлийн үр сүмбэр уул мэт болсон ч тэр бүгд ариусмуй.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг бичсэн, бусдаар бичүүлсэн тэдгээр шулмын ад зэтгэр, муу зүгийн тэнгэр нүгүүд, хүн болон хүн бусын хорлолд үл автмуй.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг бичсэн, бусдаар бичүүлсэн тэдгээр нас нөгцөхийн цагт ерөн есөн дүнчүүр [990 000 000] бурхадаас даруй бошиг хүртэх болно. Мянган тоот бурхад түүнд мутраа сунгаж, тэдгээр бурхадын ариун газарт нэгээс нөгөөд зорчих болой. Үүнд эргэлзэх,тээнгэлзэхийн хэрэг гүгү болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг бичсэн, бусдаар бичүүлсэн тэдгээрийг дөрвөн зүгийн дөрвөн их хаан сахиус бүгд сахин, хамгаалах болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг бичсэн, бусдаар бичүүлсэн тэр бүгд түүнчлэн ирсэн, цаглашгүй гэрэлт Амитаба бурхны ариун дагшин оронд төрөх болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг бичсэн тэр газар орон ариун тахилын оронд хувирч, амьтны төрөлд төрсөн араатан, жүгүүртэн бүхэн энэ тарнийн дуун агаарт дуурьсахыг сонсох тэр даруйд гэгээрлийн үрийг олж уг [амьтны] төрлөө баран төгсгөж ариусан, төгс гэгээрэх болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг бичсэн, бусдаар бичүүлсэн тэр бүгд эм төрөлд хэзээ ч эс төрмүй.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Сударыг номлох чуулган дор нэгэн зоосны өргөл өргөсөн тэр бүгд гурван мянган их мянган ертөнцийг долоон зүйл эрдэнээр дүүргэж өргөл өргөсөнтэй адил болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Сударыг номлох чуулган дор өргөл өргөсөн тэр бүгд дээдийн ном бүгдэд өргөл өргөсөнтэй адил болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр түүнчлэн ирсэн Намсиг, түүнчлэн ирсэн Цүгторчэн, түүнчлэн ирсэн Тамчэдкиоб, түүнчлэн ирсэн Лодрог Тэдзэл, түүнчлэн ирсэн Цэтүб, түүнчлэн ирсэн Үсунг, Шатүг болон бусад түүнчлэн ирэгсэд өргөсөн өргөлийг тоолж хэмжиж болох боловч Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судрын [Насны Цэнд] ашиг тусыг тоолж хэмжих аргагүй болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Уулсын хаан сүмбэр уулын чинээ эрдэнийг овоолон өргөл өргөснийг тоолж хэмжиж болох боловч Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судрын [Насны Цэнд] ашиг тусыг тоолж хэмжих аргагүй болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Замбуу тивийг дөрвөн далай усаар бүрхэх болоход тэдгээрийн дуслыг тоолж хэмжиж болох боловч Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судрын [Насны Цэнд] тус эрдмийг тоолж хэмжих аргагүй болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Хэн бээр Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний Судар [Насны Цэнд] үүнийг хүндлэн тахих, бичих хийгээд [бичсэн] түүнийг хүндлэн дээдлэх нь арван зүгийн түүнчлэн ирсэн бурхан бүгдэд авралыг одуулж, дээдлэн тахисан болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА АБАРИМИДА БУНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Өглөгийн үрээр Бурхан багш хүмүүний арслан [*араатны хаан арслан гэдэг шиг өглөгийн үрээр хүн төрөлхтөний дээд хаан нь болсон гэсэн утгатай Орч.*] болсон тэр мэт хэн нэгэн нигүүлсэхүйн хотод орохын цагт түүний өглөгийг магтан сайшаах дуун дуурьсах болой.

Ёс суртахууны хүчээр Бурхан багш хүмүүний арслан [*араатны хаан арслан гэдэг шиг ёс суртанхууны буяны хүн төрөлхтөний дээд хаан нь болсон гэсэн утгатай Орч.*] болсон тэр мэт хэн нэгэн нигүүлсэхүйн хотод орохын цагт түүний ёс суртахууныг магтан сайшаах дуун дуурьсах болой.

Тэвчээр хатуужлын хүчээр Бурхан багш хүмүүний арслан [*араатны хаан арслан гэдэг шиг тэвчээр хатуужлын үрээр хүн төрөлхтөний дээд хаан нь болсон гэсэн утгатай Орч.*] болсон тэр мэт хэн нэгэн нигүүлсэхүйн хотод орохын цагт түүний тэвчээр хатуужлыг магтан сайшаах дуун дуурьсах болой.

Сайн буяны үрээр Бурхан багш хүмүүний арслан [*араатны хаан арслан гэдэг шиг сайн буяны үрээр хүн төрөлхтөний дээд хаан нь болсон гэсэн утгатай Орч.*] болсон тэр мэт хэн нэгэн нигүүлсэхүйн хотод орохын цагт түүний сайн буяныг магтан сайшаах дуун дуурьсах болой.

Нэгэн үзүүрт сэтгэлээр бясалгал дияныг хийсний үрээр Бурхан багш хүмүүний арслан [*араатны хаан арслан гэдэг шиг нэгэн үзүүрт сэтгэлээр бясалгасны үрээр хүн төрөлхтөний дээд хаан нь болсон гэсэн утгатай Орч.*] болсон тэр мэт хэн нэгэн нигүүлсэхүйн хотод орохын цагт түүний нэгэн үзүүрт сэтгэлийн бясалгалын хүчийг магтан сайшаах дуун дуурьсах болой.

Билгэ билгүүний хүчээр Бурхан багш хүмүүний арслан [*араатны хаан арслан гэдэг шиг Билгэ билгүүний үрээр хүн төрөлхтөний дээд хаан нь болсон гэсэн утгатай Орч.*] болсон тэр мэт хэн нэгэн нигүүлсэхүйн хотод орохын цагт түүний Билгэ бүлгүүний хүчийг магтан сайшаах дуун дуурьсах болой.

УМ НАМО ВАГАВАДЭ АБАРИМИДА АЮУРЗАНА СУВИНИ ШИДАДЭ ЗОРА ЗАЯА ДАТАГАДАЯА АРАХАДЭ САМЯГ САМБУДДАЯА ДАТЯАТА УМ БУНЬЯА БУНЬЯА МАХА БУНЬЯА АБАРИМИДА

БҮНЬЯА АБАРИМИДА БҮНЬЯА ЗАНА САМБАРО БАЗИДЭ УМ САРВА САМСАГАРА БАРИ ШУДДА ДАРМААДЭ ГАГАНА САМУД ГАДЭ СУВАВА БИШҮДДЭ МАХАНАЯА БАРИ ВААРЭ СУХА.

Ялж төгс нөгцсөн, түүнчлэн ирсэн Бурхан багш ийнхүү айлдсан болой.

Орь залуу Манзушри хийгээд сайн буяны хотол чуулган болсон олон шавь нар, тэнгэр, асур, хүмүүнийн ертөнц ба үнэр идэштэн бүгдээр ялж төгс нөгцсөн, түүнчлэн ирсэн Бурхан багшийг магтан дуулвай.

“Хутагт Насан хийгээд Цаглашгүй Билгэ Билгүүний судар” үгээр төгсвэй.

Эх болсон хамаг амьтны тусын тулд болтугай

Насны Цэнд - судрын ашиг, тус эрдэм

[Зона Рэнбүүчи багш энэхүү тус эрдмийн тайлбарыг хийжэээ Орч.]

Судрын ихэнх хэсгийг олон дахин давтсан тарни эзлэж байна. Энд уг судрын ашиг, тус эрдмийг эхлэн өгүүлээд, дараа нь тарнийг давтах, ашиг, тус эрдмийг дахин өгүүлээд тарнийг дахин давтах гэсэн дараалалтай юм. Өдгөөг хүртэл энэ судар Англи хэлэнд хөрвүүлэгдээгүй байсан тул хүмүүс төвд багшаасаа энэхүү судрыг номлох хүсэлт их гаргадаг байжээ. Энэ судрыг Англи хэлэнд буулгаснаар одоо үүнийг найз нөхөд болон хүнд өвчин туссан хэн бүхэнд номлох боломжтой болж байгаа юм. Өнөө цагт ялангуяа хорт хавдар гэдэг хамгийн том асуудал болж байгаа шүү дээ.

Энэ судрын үг, үсэг бүхэн хэмжээлшгүй үнэ цэнэтэй бөгөөд энэ судрыг бичсэн, хэвлүүлсэн ашиг, тус эрдэм цаглашгүй билээ. Намайг Монголд байхад надад өгсөн энэхүү судрын нэг хувийг шүүр, сувд болон бусад эрдэнээр бүтээсэн байв. Судар үүнийг алтаар бүтээвээс муу үйлийн үр сүмбэр уул мэт боловч түүнийг ариусгах болно. Наландарын хийд долоо хоног бүр тодорхой тоогоор энэ судрыг хэвлэдэг бөгөөд нэг хувийг хэвлэх бүрт Бурхан багшийн наян дөрвөн мянган сургаалыг бүтээж хэвлэж буйтай адил ашиг, тус эрдэмтэй болохыг төсөөлөөд үзээрэй. Энэ судрыг бичсэнээр буян машид арвидна. Энэ судрыг зөвхөн хэн нэгэнд хэрэгтэй гэдэг утгаар бус мөн урт насалж, буян цаглашгүй ихээр хураахын тухайд бичвээс зохилтой.

Хэн нэгэн хүнд өвчин туссан хүнд зориулах болон бусад ажил төрөл бүтээхийн тулд энэхүү судрыг хэвлэх нь маш их тустай. Хэрэв таны бизнес амжилт муутай, бизнесээ эхлэхэд саад тотгортой бол, ажил төрөл олдох нь бэрх, бүтэмж муутай бол тус судрыг олон хувь хэвлэх хэрэгтэй. Энэ судрыг долоо хоног, сар бүр олон хувь хэвлэсэнээр энэ орчлонгийн үйлнээ буян хураагаад зогсохгүй дээдийн номын үйлнээ хэмжээлшгүй буяныг хурааж байгаа юм. Ингэж хураасан буянаа хамаг амьтны тусын тулд зориулах хэрэгтэй. Энэ нь амжилтанд хүрэх, урт наслах хамгийн зөв шийдэл болой. Мөн нас эцэслэх тэр цагт цаглашгүй гэрэлт Амиитаба бурхны ариун орноо төрөх болно.

Энэ судрыг орчуулсны ашиг, тус эрдэм нь хамаг амьтны тусын тулд болтугай. Энэ судрыг үзсэн, барьсан хийгээд санасан хэн бүхний муу үйлийн үр ариусч, тэд бүгдээр муу заяанд эгнэгт үл төрөх хийгээд үхэл ирэхийн цагт судар үүнийг үзэх төдийд амирлах болтугай. Энэ судрыг сонссон хийгээд төсөөлсөн тэр бүхний энэрэн нигүүлсэхүй ба дээд бодийн сэтгэл ямагт төрөх хийгээд хоосон чанарыг илтэд онохын тулд урт наслах болтугай. Тэд бүгдээр дээдийн номын мөрийг энэ насандаа олох хийгээд амьтан бүхэнд харшлах муу үйлээс ямагт ангид байж сайн үйлийг үргэлж цогцлоох болтугай. Энэ [орчуулсан] судар орчлонгийн хамаг амьтан төгс гэгээрэх хүртэл ашиг, тус эрдэм цаглашгүй байх болтугай.

Зуулт тайлбар:

1. Ялж Төгс Нөгцсөн (Санс. Bhagavan) – Шагжамүни бурханы нэгэн илт өгүүлэх алдар бөгөөд зургаан эрдэм төгсөж, хоёр хязгаараас хагацан дөрвөн шуламыг дарсан тул ийнхүү нэрийджээ. Өөрөөр хэлвэл, хамаг номын чанарыг төгс онож, хамаг нисваанис хийгээд мэдэгдэхүүний түйтгэрээс хагацсаны тул амьтанд барихгүй, аминд баримтлахгүй, бодгалд баримтлахгүй болсныг илэрхийлнэ. Учир нь тэрбээр хамаг хуран мэдэхүй лүгээ хагацсан нэгэн мөн болой.

2. Түүнчлэн Ирсэн (Tathagata) – бурханы илт өгүүлэх нэгэн нэр. Бурхан болохын мөр бүхэн ямар мэт, түүнчлэн ёсоор нь туулж ирсэн гэсэн утга болно. Эл сударт зарлиглахдаа: “Би хэмээхэд болоод амьтанд, аминд, бас бээр бодгалд баримтлах үзэлт болохын учирт Түүнчлэн Ирсэн нь “би бээр олон амьтныг тонилгон гэтэлгэвэй” хэмээн үл таалмой. Тэрчлэн Чакравартын хаан ч бас Түүнчлэн ирсэн болчих тул лагшин бэлгэ хотол төгссөнийг Түүнчлэн Ирсэнд үл үзэх бөлгөө. Учир нь хамаг бурхад номын чанар бөгөөтөл тэрхүү номын чанар нь мэдэгдэхүүн бус юм. Тиймээс, Түүнчлэн Ирэгсэдийг дүрсэд үзэгч, дуунд мэдэгч тэдгээр нь эндүү ташимгай үзэлт мөн болой”.

3. Дайснаа дарсан (санс. Arhat) – хорт сэтгэл буюу нисваанисын дайсныг дарсан архадыг илт өгүүлэх нэр. Эл сударт Субути бээр өгүүлэхдээ: “хэрвээ Дайснаа Дарсан [архад], “би бээр Дайснаа Дарсан [архадын] хутгийг оллоо” хэмээн сэтгэвээс, тэр ямагт тэрээр би хэмээн баримтлах болмуй. Амьтанд баримтлах, аминд баримтлах хийгээд бодгалд баримтлах болмой. Үнэн Төгс Туулсан Бурхан бээр намайг нисваанис үгүй оршигсодын манлайн дээд хэмээн үзүүлсэн болой. Хэдийгээр би шунал тачаал лугаа хагацсан Дайснаа Дарсан Архад мөн боловч “би болвоос Дайснаа Дарсан болой” хэмээн үл сэтгэмүй. Учир нь хэрвээ би тэр мэт сэтгэх бөгөөс, Түүнчлэн Ирсэн бээр намайг “язгууртаны хөвгүүн Субути болвоос нисваанис үгүй оршигсодын манлайн дээд мөн бөгөөд юунд ч эс оршсон нь нисваанис үгүй оршсон” хэмээн бивангирд эс үзүүлэх болмуй” хэмээжээ.

4. Үнэн Төгс Туулсан – бурханы (илт өгүүлэх) нэгэн алдар нэр. Бурхан болох мөр бүхнийг үнэн төгс туулан бүтээсэн гэсэн үг.

5. Шравасти (Санс. shravasti) – Шагжамүни бурхан багшийн үеийн нэгэн хотын нэр.

6. Жэта (Санс. Jeta) – “Ялгуугч” хэмээх утга бүхий хүний нэр. Энд Ялгуугч хан хөвгүүний цэцэрлэг хэмээх нэрэмжит газрын нэрийн утгаар оржээ.

7. Бурхан багшийн нэгэн гол өглөгийн эзэн.

8. Аягха тахимлиг- (Санс. Bhikshu. Тө. гэлэн)-шашны ёсны 253 зүйл сахил санваар сахигч хувраг хүн.

9. Бодьсадва-Хамаг амьтны тусын тулд төгс бодийн хутагт илтэд туулсан бурхан болохыг зоригдон их хөлгөний мөрийн эрдэм ухааныг бүтээгч бөлгөө. Бодьсадвын үндсэн 18, гишүүн 46 сахилыг сахих бөгөөд туулан бүтээх 10 газар мөр бий. Эл сударт Ялж Төгс Нөгцсөн Бурхан бээр зарлиглахдаа: “бодьсадвын хөлгөнд орсон бээр эх болсон хамаг амьтныг нэгээхэн ч хоцроолгүй нирвааны төвд (паринирваанд) оруулсугай. Тэр мэтээр цаглашгүй амьтныг паринирваанд оруулавч амьтан бүр хараахан бас паринирваанд орсонгүй [хэвээр] болой хэмээх сэтгэлийг үүсгэсэн, тэрчлэн амьтанд, аминд хийгээд бодгалд хураан мэдэхүй үл орж үйлдэх бөгөөд ер алин юунд ч үл баримтлан өглөг өгөгчийг бодьсадва” хэмээжээ.

10. Махасадва - Их төрөлхтөн

Орчуулгын тухай:

- Санкрит хэлнээс Төвд хэлэнд Энэтхэгийн их бандида Бүнье Самбава болон Төвдийн хөрвүүлэгч Пацаб Няма Драг
- Англи хэлнээ 2005 онд хөрвүүлж, тайлбар зүүлт хийсэн Зопа Рэнбүүчи багш, Качоэ Дэчэн Линг лам. Бичиж, шивсэн эрхэм хүндэт Түбдэн Ладроб. Зөвлөгөө өгч, засварласан доктор Грегорий Хиллс.
- Энэхүү судрын орчуулагыг [Их Хөлгөний Уламжлалын Хадгалах Төвийн вэб сайтад](#) тавигдсан Зоп Рэнбүүчи багшийн англи хэлэнд буулгасан “[Unfathomable Exalted Life and Transcendental Wisdom](#)” сударыг эх болгон мөн <http://www.saraswatibhawan.org/> вэб сайтад байрлах бас нэг [англи хувилбартай](#) харьцуулан байж Англи хэлнээс буулгав. Мөн вэб сайтад тавигдсан Х. Булган ламын орчуулсан “[Хутагт Алтангэрэл буюу Судрын амгийн дээд эрхэт хаан хэмээх их хөлгөний судар](#)”, Ч. Хатанбаатарын төвд хэлнээс орчуулсан “[Хутагт Билгийн Чинад Хязгаараа Хүрсэн Очироор Огтлогч хэмээх их хөлгөн судар](#)” сударуудын орчуулгын хэв загварын дагуу буулгахыг машид хичээлээ. Эдгээр эрдэмт хүмүүсийн орчуулагууд нь яруу тансаг дорнын нэг хэлээс [Төвд, Энэтхэг] хэлээс нөгөөд [Монгол] орчуулагдсан, бас орчуулагч нарын авьяас чадал, эрдэм ухааны царааг илтгэсэн сайхан бүтээлүүд гэдэг нь илэрхий. Эгэл миний орчуулгын хувьд бүтэц, хэв загварын хувьд тэс ондоо өрнийн нэгэн хэлээс [Англи] дорнын хэлнээ [Монгол], бас би мэргэжлийн орчуулагч биш, энэ талын авьяас чадал муутайг хэлэх үү болхи орчуулага болсон гэдэг нь илэрхий тул хүлцэл эрмүй.

Монгол газарт билгийн тооллын XVII жарны “Баясгалан” хэмээх усан луу жилийн харвын тэргүүн сарын шинийн арван таван, аргын 2012 оны 3 дугаар сарын 8-д Лос Анжэлэс хотод Монгол хэлнээ буулгаж дуусав.

Лам Р.Алтантитэм, лам Л.Рэнчин, лам Д.Норовбадам нар зөвлөн туслаж, засварлан хянав. Үг үсгийн алдааг хянаж, засварласан Цагаантуг овогт М.Саруул-Эрдэнэ.

Ноёнцорос овогт Н.Даваасүрэн